“Дерма” аппликэйшнаар дамжуулан лавлагаа төвд оношлогдсон арьсны өвчнүүд

О.Сувд-Эрдэнэ[1], Л.Ундрам[2], Б.Хандсүрэн[3]

[1]Эрдмийн Сургууль, АШУҮИС
[2]НЭМС, АШУҮИС
[3]АУС. АШУҮИС

Үндэслэл: Арьсны өвчнийг зайнаас оношилж эмчлэхэд зориулагдсан ухаалаг гар утасны “Дерма” аппликэйшныг 2015 онд улсын хэмжээнд нэвтрүүлсэнээс хойш теледерматологи хэрэгжиж буй аймгуудын цахим мэдээллийн санд бүртгэгдсэн өвчлөлд дүн шинжилгээ хийсэн тоо баримт хомс байсан нь бидний судалгааны үндэслэл боллоо.
Зорилго: Сэлэнгэ, Сүхбаатар, Хөвсгөл аймгийн “Дерма” аппликэйшнд бүртгэгдсэн арьсны өвчлөлийг судалж, лавлагаа төвд оношлогдсон өвчнийг тодорхойлох
Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй: Энэхүү судалгаанд Сэлэнгэ, Сүхбаатар, Хөвсгөл аймгийн “Дерма” аппликэйшны цахим мэдээллийн санд 2015 оны 6 сараас 2016 оны 6 сар хүртэлх нэг жилийн хугацаанд бүртгэгдсэн 862 тохиолдолд тулгуурлан дескриптив, ретроспектив судалгааны загвараар судалгааг хийж гүйцэтгэв. Цахим программд бүртгэгдсэн нийт өвчнийг Өвчний Олон Улсын 10-р ангилалаар ангилсан болно.
Үр дүн: Судалгаанд хамрагдсан 862 үйлчлүүлэгчдэд нийт 85 нэр төрөл бүхий 7 бүлэг өвчин оношлогдсоноос арьс ба арьсан доорх эслэгийн өвчин (L00-L99) бүлэгт 686 тохиолдол бүртгэгдэж, нийт өвчлөлийн 79,6%-г эзэлсэн бөгөөд 14,4% нь лавлагаа төвд оношлогдсон, халдварт ба шимэгчит зарим өвчин (A00-B99) бүлэгт 155 тохиолдол бүртгэгдэж, нийт өвчлөлийн 18%-г эзэлсэн бөгөөд 18,7% нь лавлагаа төв (Арьс судлалын тэнхим)-д оношлогдсон бол үлдсэн 2,4%-д өмөн (C00-D48), дотоод шүүрэл, тэжээл ба бодисын солилцооны өвчин (E00-E90), хоол боловсруулах тогтолцооны өвчин (K00-K93), яс булчингийн тогтолцоо ба холбох эдийн өвчин (M00-M99), төрөлх гажиг, гаж хөгжил ба хромосомын эмгэг (Q00-Q99) бүлгийн өвчнүүд тохиолдсон бөгөөд эдгээрийн 71,5% нь лавлагаа төвд оношлогджээ. Лавлагаа төвийн тусламж үйлчилгээний дийлэнх хувийг эзэлж буй өвчнүүдэд халдварт ба шимэгчит зарим өвчний бүлэгт хамаарах арьсны сүрьеэ, ёлом, хоёрдогч тэмбүү, хучуур эсийн хорт хавдар, шархлаат стоматит, лейкоплаки зэрэг өвчнүүд нь 100% лавлагаа төвд оношлогдсон. Харин өмөн бүлэгт багтах хавдрын бус мэнгэ, гемангиом, ургацаг, фиброма зэрэг өвчний 70%, дотоод шүүрэл, тэжээл ба бодисын солилцооны өвчний бүлэгт хамаарах арьсаар илрэх порфири өвчний 75%, төрөлх гажиг, гаж хөгжил ба хромосомын эмгэг бүлэгт хамаарах Реклингхаузены өвчний 66,7%-г лавлагаа төвд оношилсон байв.
Дүгнэлт: Дерма аппликейшнээр дамжуулан Арьсны өвчний тусламж үзүүлэхэд Арьс судлалын практикт цөөн тохиолддог арьсны өвчнүүд нь зонхилон лавлагаа төвд оношлогджээ.

Түлхүүр үг: зайн арьс судлал, арьсны өвчин

ШУТЭЛ

Dermatologic diseases diagnosed through “derma” application at the Reference center

Suvd-Erdene O[1], Undram L[2], Khandsuren B[3]

[1]Academic School, MNUMS
[2]School of Public Health, MNUMS
[3]School of Medicine, MNUMS

Introduction: Application “Derma” for smartphones is an application designated to diagnose dermatologic diseases from distance, which was implemented nationwide since 2015. However, the data analysis of illnesses registered in the electronic information database from the provinces was poor, which served as a background for this study.
Purpose: To study dermatologic illnesses registered through “Derma” application at the Selenge, Sukhbaatar, Khuvsgul provinces, and to determine the incidence of diseases diagnosed at the Reference center.
Materials and methods: Based on the 862 cases registered through “Derma” application from Selenge, Sukhbaatar, Huvsgul provinces during June 2015-June 2016, a descriptive retrospective analysis was conducted. All diseases were classified according to the International Statistical Classification of Diseases 10th Revision.
Results: A total of 85 different nosologic entities subdivided into 7 groups were diagnosed. The most prevalent ones were diseases of the skin and subcutaneous tissue (L00-L99) 686 (79.6%) from which 14.4% were diagnosed at the reference center; certain infectious and parasitic disease (A00-B99) 155 (18%) - 18.7% were diagnosed at the reference center and the remaining 2.4% were composed of neoplasm (C00-D48), endocrine, nutritional and metabolic diseases (E00-E90), disease of the digestive system (K00-K93), disease of the musculoskeletal system and connective tissue (M00-M99), congenital malformations, deformations and chromosomal abnormalities (Q00-Q99), 71.5% of which were diagnosed at the Reference center. Entities such as infectious and parasitic diseases, including skin tuberculosis, erysipelas, secondary syphilis, epithelial tumors, aphthous stomatitis, and leukoplakia were diagnosed 100% at the Reference center, followed by the diseases belonging to the endocrine, nutritional, and metabolic illnesses with skin manifestations such as porphyria 75%, diseases belonging to the neoplasms (non-cancerous mole, hemangioma, polyp, fibroma) 70% and diseases belonging to congenital malformations, deformations and chromosomal abnormalities including von Recklinghausen's disease 66.7%.
Conclusion: According to the “Derma” registration of skin diseases diagnosed at the Reference center, the most prevalent skin disorders were the uncommon ones.

Keywords: teledermatology, dermatologic disease